

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал	10
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГА Х.ХЭРЛЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/296
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Ашигт малтмал, газрын тосны газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/521 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ашигт малтмал, газрын тосны газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Ашигт малтмал, газрын тосны газар нь “Төрөөс геологи, уул уурхай, газрын тосны салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд ашигт малтмал, газрын тосны салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Ашигт малтмалын тухай хуулиар тус газрын үйл ажиллагааны 21, Газрын тосны тухай хуулиар 23 чиг үүргийг тус тус тодорхойлсон байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Ашигт малтмал, газрын тосны газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Газрын тосны тухай хууль
- Ашигт малтмалын тухай хууль
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал болон холбогдох бусад тушаал шийдвэрүүд.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газар нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Хүлэгт хүннү Аудит” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байгаа бөгөөд эцэслэн батлагдаагүй байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Ашигт малтмал, газрын тосны газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “unicus” програм хангамж ашиглаж байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ашигт малтмал, газрын тосны газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг

баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг үе шатны ажлуудад материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 2,907,820.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 15 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 4 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	4,303,055.0	
2	Албан шаардлага өгсөн	2	9,115,929.1	
	Дүн	8	13,418,984.1	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- 2014-2015 онуудад улсын төсөвт бүрдүүлж, төвлөрүүлэх орлогыг Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу бүртгэл хөтлөн 12 байгууллагаас авах 8,334,146.8 мянган төгрөгийн, үйл ажиллагааны урсгал зардалтай холбоотой 9,858.1 мянган төгрөгийн, насжилт ихтэй авлага, 2,375.7 мянган төгрөгийн өглөг үүсгэснийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.
- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төвлөрүүлж, зарцуулахаар төсөвт батлагдсан сургалтын урамшууллын буюу үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөөг 769,548.5 мянган төгрөгөөр тасалсан.

Шийдвэрлэсэн нь: Дээр дурдсан 9,115,929.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 2 албан шаардлага хүргүүлэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын явцад анхаарал татахуйц дараах асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

1. Өөрийн орлого бүрдүүлэлтэд мөрдөгдөх “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг шинээр баталж, хэрэгжүүлсэн, зарим орон нутгийн удирдлагын гаргасан шийдвэрээр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зогсоосон зэрэг асуудлаас шалтгаалан улсын төсвийн орлого 13,935,500.7 мянган төгрөгөөр тасарсан байна.

2. Улсын төсөвт төвлөрүүлэх “Өөрийн орлого” буюу Сонгон шалгаруулалтын орлогоос 4,885,000.0 мянган төгрөгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/203 дугаар тушаалаар “Туслах үйл ажиллагааны орлого”-оор тооцож, Геологи хайгуул, судалгааны ажилд 3,994,800.0 мянган төгрөгийг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрдэм шинжилгээ судалгааны ажилд 459,200.0 мянган төгрөгийг, хөтөлбөр төслийн дотоод урсгал зардалд 396,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар шийдвэрлэсний дагуу АМГТГ нь 4,600,000.0 мянган төгрөгийг урсгал санхүүжилтаар гаргаж, тайлагнасан байна.

3. 2016 оны 2, 3 дугаар сард хуучнаар Газрын тосны газрын төсвийн захирагчийн гаргасан буруутай шийдвэрээр 5 хүнийг ажлаас халсныг Шүүхийн шийдвэрээр хүчингүй болгож, ажилгүй байсан хугацааны нийт 40,781.8 мянган төгрөгийн нөхөн олговрыг олгосон байна.

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараагийн аудитаар дараах асуудлуудыг нарийвчлан авч үзнэ. Үүнд:

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу бүрдүүлж, зарцуулагддаг “Сургалтын урамшуулал”-ын хөрөнгийн зарцуулалт, гэрээний хэрэгжилт, үр нөлөөт байдлын талаар нарийвчлан авч үзнэ.

2. Сангийн яамнаас хийгддэг улсын төсвийн орлогын буцаалтын ажил гүйлгээг АМГТГ-ын санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд тайлагнасан бөгөөд анхан шатны баримт материалыг архивлан хадгалаагүй тул дараагийн аудитаар нарийвчлан горим сорил хэрэгжүүлнэ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Ашигт малтмал, газрын тосны газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 12 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 5,995,961.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 5,221,401.3 мянган төгрөг буюу 87.1 хувьтай байгаа нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төвлөрөх сургалтын урамшууллын орлого бүрэн бүрдээгүйгээс уг эх үүсвэрээр санхүүжигдэх зардлын гүйцэтгэл дутуу гарсантай холбоотой байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Ашигт малтмал, газрын тосны газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудитын нэгжээс 2018 оны 10 сарын байдлаар мэдээлэл хугацаа хоцроосон, төсөв гүйцэтгэл, хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг оруулаагүй байсныг анхааруулж, зөвлөмж өгсөн байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 94 хувьтай байна. Дараах зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, батлуулж мөрдөх гэсэн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Хүлэгт хүннү Аудит ХХК-тай 2017 оны 10 дугаар сард 2017/50 дугаартай гэрээ байгуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд, эцэслэн батлагдаагүй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав. Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ашигт малтмал, газрын тосны газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Орлогын талаар

3.1.1 Илрүүлэлт:

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг мөнгөн хөрөнгийн орох урсгалыг үндэслэн санхүүгийн үр дүнгийн тайланд давхар хүлээн зөвшөөрч тайлагнаж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруз сууриар хөтөлнө”, Сангийн сайдын 2008 оны 352 дугаар тушаалын 1-д “Төсөвт байгууллага нь төсвийн орлогыг цуглуулан төсөвт төвлөрүүлэх тохиолдолд дараах байдлаар бүртгэнэ: Дт Мөнгөн хөрөнгө-харилцах, Кт Өглөг-төсөвт төвлөрүүлэх орлого” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Мөн өөрийн орлого буюу Сонгон шалгаруулалтын орлогыг “Урьдчилж орсон орлого”-оор бус байгууллагад төлөх өглөгөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан зааврын 2.8-д “Ажил үйлчилгээг нийлүүлээгүй байхад хүлээн авсан орлогыг урьдчилж орсон орлого гэж хүлээн зөвшөөрч бүртгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан дахь орлогын гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

3.1.3 Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт орлогын дансдын бүртгэлийн бодлогыг тодорхой тусган батлуулж, мөрдөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Мөнгөн хөрөнгийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Сангийн яамны Төрийн сангийн газарт анхан шатны баримт материалыг хянан хүлээн авч, шилжүүлсэн 2,368,584.8 мянган төгрөгийн улсын төсвийн орлогын буцаалтын ажил гүйлгээг мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд бүртгэсэн нь “Тохиолдсон байх”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаагаас гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүд зөрчигдөж, цаашид санхүүгийн тайланд материаллаг хэмжээгээр нөлөөлөх.

3.2.3 Зөвлөмж:

Улсын төсвийн буцаалтын ажил гүйлгээг холбогдох хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэж, бүртгэл тайланд тусгах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Төсвийн гүйцэтгэлийн талаар

3.3.1 Илрүүлэлт

Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих” зориулалтаар 1,311,519.5 мянган төгрөгийн орлого төвлөрснийг төсөвт тусгаж батлуулалгүйгээр зарцуулсан.

3.3.2 Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомжууд зөрчигдөж, төсвийн хөрөнгө дотоод хяналтгүй, үр ашиггүй зарцуулагдах.

3.3.4 Зөвлөмж:

Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлогыг төсөвт тусган, батлуулж зарцуулах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Зардлын талаар

3.4.1 Илрүүлэлт:

Зардлын тайлагнал, зарцуулалттай холбоотой дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

- Үндсэн нэмэгдэл цалин, унаа хоолны хөнгөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлүүд, гадаад, дотоод албан томилолтын нийт 530,849.8 мянган төгрөгийн зардлыг мөнгөн гүйлгээний тайланд бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнаагүй,
- Түлш, халаалтын болон бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс авах зардлаас 39,646.8 мянган төгрөгийг урсгал засварын зардалд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй,
- Гадаад албан томилолтын зардлаас 28,203.5 мянган төгрөгийг хурлын заалны төлбөр, бэлэг дурсгал, хэвлэл зэрэгт зарцуулсан байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах" гэж заасантай болон Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, дотоод хяналтгүй зарцуулагдах, санхүүгийн тайлан дахь зардлын дансд буруу илэрхийлэгдэж хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүрэх.

3.4.3 Зөвлөмж:

3.4.3.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх,

3.4.3.2. Мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын дансыг бодит гүйцэтгэлд үндэслэн, үнэн зөв тайлагнаж байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Бараа материалын талаар

3.5.1 Илрүүлэлт:

Албан хаагчдад олгосон 24,250.7 мянган төгрөгийн нормын хувцсыг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь УСНББОУС-12 "Бараа материал"-ын 9(б)-д "Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө" гэсэн тодорхойлолттой нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө дотоод хяналтгүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.

3.5.3 Зөвлөмж:

Тайлант онд олгосон нормын хувцсыг албан хаагч нэг бүрээр буцаан орлого авч, картлан эзэмшүүлэх.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>35,179,430,860.18</u>	<u>34,748,409,739.59</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	601,586,281.99	1,641,395,296.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	598,917,506.93	1,641,395,296.00
3121	Төгрөг	0.34	1,641,395,296.00
31211	Төрийн сангийн харилцах	-	1,641,395,296.00
31213	Арилжааны банк дахь харилцах	0.34	-
3122	Гадаад валют	598,917,506.59	-
31223	Арилжааны банк дахь харилцах	598,917,506.59	-
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	2,668,775.06	-
33	АВЛАГА	10,577,409,716.32	9,084,637,972.47
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	310,691.32
335	Бусад авлага	10,577,409,716.32	9,084,327,281.15
3351	Байгууллагаас авах авлага	10,555,301,843.19	9,059,425,322.62
3352	Хувь хүмүүсээс авах авлага	22,107,873.13	24,901,958.53
34	УРЬДЧИЛГАА	283,836,841.25	281,936,598.47
34600	Урьдчилж гарсан зардал	268,217,576.25	279,917,576.25
3471	Урьдчилгаа тооцоо	15,619,265.00	2,019,022.22
34714	Томилолтын урьдчилгаа	15,619,265.00	2,019,022.22
35	БАРАА МАТЕРИАЛ	541,207,667.34	565,049,519.37
35300	Бэлэн бүтээгдэхүүн	5,229,344.92	4,421,290.00
354	Хангамжийн материал	535,978,322.42	560,628,229.37
35410	Бичиг хэргийн материал	18,919,201.05	13,791,580.11
35420	Аж ахуйн материал	477,268,337.94	514,881,649.29
35430	Сэлбэг хэрэгсэл	15,612,789.91	20,040,489.91
35440	Түлш, шатах тослох материал	24,177,993.52	11,914,510.06
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390,353.28	23,175,390,353.28
36400	Шатахууны нөөц	23,175,390,353.28	23,175,390,353.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,136,873,327.93</u>	<u>9,684,711,913.52</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,136,873,327.93	9,684,711,913.52
392	Биет хөрөнгө	7,751,953,497.28	8,871,812,915.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,573,149,404.58	5,363,350,894.54
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,688,209,815.85	-
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,476,534,117.94	2,674,534,117.94
39204	Хуримтлагдсан элэгдэл	1,281,446,750.86	1,647,724,912.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,504,524,675.42	6,771,463,188.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	4,298,172,957.89	4,832,915,154.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,026,176,252.17	1,102,977,429.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	811,401,155.94	845,519,418.87
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	487,821,320.00	487,821,320.00

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39212	Хуримтлагдсан элэгдэл	364,811,052.29	408,447,797.78
39214	Бусад үндсэн хөрөнгө	46,981,100.00	694,050,278.87
39215	Хуримтлагдсан элэгдэл	9,358,400.00	487,777,028.73
39216	Дуусаагүй барилга, байгууламж	90,166,760.00	
393	Биет бус хөрөнгө	384,919,830.65	812,898,997.80
39301	Програм хангамж	1,310,806,826.39	1,669,524,379.19
39302	Хуримтлагдсан элэгдэл	925,886,995.74	1,064,794,996.39
39303	Бусад биет бус хөрөнгө		208,169,615.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>43,316,304,188.11</u>	<u>44,433,121,653.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,280,044,078.76</u>	<u>2,369,498,415.75</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,280,044,078.76	2,369,498,415.75
413	Өглөг	2,280,044,078.76	2,369,498,415.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	41,080,438.00	-
4136	Бусад өглөг	2,238,963,640.76	2,369,498,415.75
41361	Байгууллагад төлөх өглөг	2,238,963,640.76	2,369,249,401.19
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	-	249,014.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>41,036,260,109.35</u>	<u>42,063,623,237.36</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	41,036,260,109.35	42,063,623,237.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,979,642,904.22	10,187,812,519.22
51101	Өмч: - төрийн	9,979,642,904.22	10,187,812,519.22
512	Хуримтлагдсан үр дүн	30,397,067,018.81	29,114,293,548.50
51210	Өмнөх үеийн үр дүн	30,397,067,018.81	30,397,067,018.81
51220	Тайлант үеийн үр дүн		(1,282,773,470.31)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	659,550,186.32	2,761,517,169.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>43,316,304,188.11</u>	<u>44,433,121,653.11</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	270,381,938,160.89	291,074,625,191.39
11	ТАТВАРЫН ОРЛОГО	44,026,124,873.31	42,666,881,769.12
118	Бусад татвар, төлбөр, хураамж	44,026,124,873.31	42,666,881,769.12
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	44,026,124,873.31	42,666,881,769.12
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	39,531,762,703.36	39,643,480,391.50
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	4,494,362,169.95	3,023,401,377.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	222,879,131,087.58	243,555,068,676.27
120	Нийтлэг татварын бус орлого	222,879,131,087.58	243,555,068,676.27
120002	Хүүгийн орлого	83,349,476.02	17,830,209.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,526,808,805.02	20,977,588,438.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,205,881,638.08	15,614,681,322.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,320,927,166.94	5,360,374,908.34
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	2,532,208.00
120006	Газрын тосны орлого	198,264,088,615.09	222,546,276,147.72
120009	Бусад орлого	4,884,191.45	13,373,879.99
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,476,682,200.00	4,852,674,746.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,476,682,200.00	4,852,674,746.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,476,682,200.00	3,367,711,200.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	1,484,963,546.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	273,963,190,077.03	290,782,040,311.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	273,963,190,077.03	290,782,040,311.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,870,622,285.71	5,566,188,003.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,446,920,433.36	2,467,515,685.70
210101	Үндсэн цалин	1,416,152,340.86	1,443,888,406.83
210102	Нэмэгдэл	724,824,203.57	699,755,918.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	303,532,900.00	320,786,760.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,410,988.93	3,084,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	267,604,420.96	303,365,941.31
210201	Тэтгэврийн даатгал	194,108,637.77	263,941,399.13
210202	Тэтгэмжийн даатгал	16,002,990.23	10,224,979.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,426,493.42	7,851,664.20
210204	Ажилгүйдлийн даатгал	3,635,253.82	1,940,034.35

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	36,431,045.72	19,407,863.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	159,195,589.68	152,580,258.31
210301	Гэрэл, цахилгаан	19,775,904.50	11,282,887.80
210302	Түлш, халаалт	93,713,051.73	110,707,368.88
210303	Цэвэр, бохир ус	22,772,595.45	11,190,94.63
210304	Байрны түрээс	22,934,038.00	19,399,057.00
2104	Хангамж, бараа материалын зардал	310,720,427.90	261,329,485.47
210401	Бичиг хэрэг	64,848,333.19	53,714,925.74
210402	Тээвэр, шатахуун	86,034,084.05	81,732,068.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,009,617.85	36,885,208.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	845,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	76,833,171.90	74,655,292.85
210408	Бараа материал акталсны зардал	40,275,220.91	13,496,989.40
2105	Нормативт зардал	-	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	169,811,042.72	96,136,234.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,034,065.00	186,640.00
210604	Урсгал засвар	163,776,977.72	95,949,594.58
2107	Томилолт, зочны зардал	183,567,542.20	321,054,105.73
210701	Гадаад албан томилолт	77,510,703.10	141,993,502.35
210702	Дотоод албан томилолт	96,248,569.10	177,007,466.80
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	9,808,270.00	2,053,136.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	843,589,854.13	659,597,372.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	585,234,779.13	585,269,073.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,000.00	2,670,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	11,114,800.00	30,298,326.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,789,318.00	5,832,905.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	480,280.00	491,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	194,063,693.00	28,436,794.24
210807	Газрын төлбөр	3,974,984.00	4,114,844.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,232,000.00	2,483,930.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,489,212,974.76	1,303,608,919.94
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,489,212,974.76	1,303,608,919.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,092,567,791.32	285,215,852,307.77
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,850,000,000.00	4,600,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,850,000,000.00	4,600,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,532,431,354.24	1,970,324,037.47
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	56,535,075.22	90,637,185.16
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,274,323,013.02	1,845,742,452.31
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	201,573,266.00	33,944,400.00

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	257,988,685,338.75	277,877,943,491.25
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	51,950,635.06	5,011,446.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	257,936,734,703.69	277,872,932,044.66
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,721,451,098.33	767,584,779.05
213404	Хөрөнгийн	1,721,451,098.33	767,584,779.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(3,581,251,916.14)	292,584,880.10
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	405,332,102.38	10,105,414.77
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	147,188,835.40	120,224.39
145003	Хөрөнгө оруулалтын олз	258,143,266.98	9,985,190.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	663,541,976.20	1,585,463,765.18
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	135,394,077.32	1,530,807,794.96
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	528,147,898.88	47,439,230.22
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	7,216,740.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(258,209,873.82)	(1,575,358,350.41)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(3,839,461,789.96)	(1,282,773,470.31)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	276,092,650,070.43	293,180,437,214.91
11	ТАТВАРЫН ОРЛОГО	44,026,124,873.31	42,666,881,769.12
118	Бусад татвар, төлбөр, хураамж	44,026,124,873.31	42,666,881,769.12
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	44,026,124,873.31	42,666,881,769.12
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	39,531,762,703.36	39,643,480,391.50
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	4,494,362,169.95	3,023,401,377.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	228,269,893,690.12	246,726,788,050.03
120	Нийтлэг татварын бус орлого	228,269,893,690.12	246,726,788,050.03
120002	Хүүгийн орлого	83,349,476.02	17,830,209.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,917,743,975.49	22,627,024,014.59
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,198,641,638.00	17,256,026,618.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,719,102,337.49	5,370,997,396.09
120006	Газрын тосны орлого	198,264,088,615.09	222,546,276,147.72
120009	Бусад орлого	2,211,623.52	7,157,678.00
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/	2,002,500,000.00	1,528,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,796,631,507.00	3,786,767,395.76
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,476,682,200.00	3,367,711,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,476,682,200.00	3,367,711,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	272,699,000.00	290,458,728.76
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	272,699,000.00	290,458,728.76
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	47,250,307.00	128,597,467.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	47,250,307.00	55,303,147.00
300001	Нэр данс зөрүүтэй орлого		73,294,320.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	275,065,284,836.59	291,495,731,292.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	275,065,284,836.59	291,495,731,292.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,681,295,862.30	4,553,838,296.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,381,202,301.55	2,565,790,440.67
210101	Үндсэн цалин	1,572,672,163.48	1,800,482,264.65
210102	Нэмэгдэл	395,237,622.50	427,625,084.91

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,076,795.15	145,820,512.25
210104	Урамшуулал	53,992,050.41	55,138,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	211,223,670.01	136,724,478.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	282,545,232.65	311,000,603.94
210201	Тэтгэврийн даатгал	282,545,232.65	226,332,703.94
210202	Тэтгэмжийн даатгал	-	21,167,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	16,933,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	4,233,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	42,334,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,195,789.68	159,980,258.31
210301	Гэрэл, цахилгаан	19,775,904.50	11,282,887.80
210302	Түлш, халаалт	100,713,051.73	110,707,368.88
210303	Цэвэр, бохир ус	22,772,595.45	11,190,944.63
210304	Байрны түрээс	22,934,238.00	26,799,057.00
2104	Хангамж, бараа материалын зардал	254,425,508.47	243,813,782.23
210401	Бичиг хэрэг	62,125,465.00	44,368,076.96
210402	Тээвэр, шатахуун	68,745,210.00	79,786,894.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,125,617.85	37,652,208.49
210404	Ном, хэвлэл	4,516,930.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	845,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	76,192,285.62	81,161,602.78
2105	Нормативт зардал	1,386,000.00	1,386,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,386,000.00	1,386,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	201,729,043.63	105,319,341.83
210601	Багаж, техник, хэрэгсэл	43,404,524.40	3,960,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,950,500.00	3,748,600.00
210604	Урсгал засвар	155,374,019.23	97,610,741.83
2107	Томилолт, зочны зардал	286,904,299.69	344,486,616.77
210701	Гадаад албан томилолт	94,864,429.10	143,399,659.15
210702	Дотоод албан томилолт	180,448,342.59	201,086,957.62
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	11,591,528.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	920,861,834.63	762,534,014.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	658,732,014.68	685,740,145.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,700,000.00	2,670,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	50,352,870.00	30,298,326.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,551,248.00	5,832,905.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	480,280.00	491,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	194,063,693.00	28,436,794.24
210807	Газрын төлбөр	3,974,984.00	4,114,844.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	111,544.95	-
210809	Улсын мэдээллийн маягт	4,895,200.00	4,949,500.00

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	186,045,852.00	59,527,237.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	186,045,852.00	59,527,237.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	270,383,988,974.29	286,941,892,996.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	6,852,500,000.00	4,600,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	6,852,500,000.00	4,600,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,672,988,603.45	2,038,586,267.51
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	47,250,307.00	55,303,147.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	58,082,369.04	90,637,185.16
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,310,582,664.22	1,858,701,535.35
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	201,573,266.00	33,944,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	55,499,997.19	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	258,012,654,067.51	277,934,721,949.44
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	75,919,363.82	61,789,904.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	257,936,734,703.69	277,872,932,044.66
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,845,846,303.33	2,368,584,779.05
213404	Хөрөнгийн	1,845,846,303.33	2,368,584,779.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,027,365,233.84	1,684,705,922.64
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	162,830,840.60	597,577,902.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	162,830,840.60	597,577,902.80
2200	Дотоод эх үүсвэрээр	162,830,840.60	597,577,902.80
221001	Их засвар	41,821,954.00	51,260,342.00
222001	Тоног төхөөрөмж	121,008,886.60	50,361,283.00
223001	Бусад хөрөнгө	-	262,109,225.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		233,847,052.80
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(162,830,840.60)	(597,577,902.80)
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	298,319,878.86	47,319,005.83
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	298,319,878.86	47,319,005.83
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(298,319,878.86)	(47,319,005.83)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	566,214,514.38	1,039,809,014.01
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	430,415,362.30	601,586,281.99
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	996,629,876.68	1,641,395,296.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	34,468,674,374.72	45,107,867,465.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-91,000,000.00	-91,000,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	34,377,674,374.72	45,016,867,465.26
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-3,980,607,355.91	-3,980,607,355.91
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	30,397,067,018.81	41,036,260,109.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,979,642,904.22	659,550,186.32	30,397,067,018.81	41,036,260,109.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		2,101,966,983.32		2,101,966,983.32
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	208,169,615.00			208,169,615.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-1,282,773,470.31	-1,282,773,470.31
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,761,517,169.64	29,114,293,548.50	42,063,623,237.36

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,995,961,200.00	5,221,401,288.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,995,961,200.00	5,221,401,288.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,321,766,800.00	3,316,780,353.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,116,699,900.00	2,113,264,687.54
210101	Үндсэн цалин	1,484,681,000.00	1,484,680,990.38
210102	Нэмэгдэл	428,804,000.00	427,625,084.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	148,076,800.00	145,820,512.25
210104	Урамшуулал	55,138,100.00	55,138,100.00
210105	Гэрээт ажлын хөлс		-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	254,003,900.00	254,003,900.00
210201	Тэтгэврийн даатгал	169,336,000.00	169,336,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	21,167,000.00	21,167,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,933,500.00	16,933,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,233,400.00	4,233,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,334,000.00	42,334,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,161,200.00	129,990,588.12
210301	Гэрэл, цахилгаан	11,105,700.00	10,847,932.80
210302	Түлш, халаалт	106,812,000.00	106,748,765.69
210303	Цэвэр, бохир ус	11,016,000.00	10,891,488.63
210304	Байрны түрээс	2,227,500.00	1,502,401.00
2104	Хангамж, бараа материалын зардал	162,928,500.00	162,795,290.93
210401	Бичиг хэрэг	39,864,800.00	39,802,426.96
210402	Тээвэр, шатахуун	62,203,900.00	62,203,894.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	35,751,600.00	35,756,177.19
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	855,400.00	780,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,252,800.00	24,252,792.78
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	1,386,000.00	1,386,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,386,000.00	1,386,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,948,700.00	20,947,983.48
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,960,000.00	3,960,000.00
210602	Тавилга		-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,138,400.00	2,138,400.00
210604	Урсгал засвар	14,850,300.00	14,849,583.48

Ашигт малтмал, газрын тосны газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	100,847,000.00	100,846,658.60
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	100,847,000.00	100,846,658.60
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	533,791,600.00	533,545,244.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	465,971,300.00	465,843,131.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,772,000.00	2,670,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	21,285,000.00	21,285,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,840,600.00	5,832,905.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	491,500.00	491,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,436,800.00	28,436,794.24
210807	Газрын төлбөр	4,044,400.00	4,036,414.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,950,000.00	4,949,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,674,194,400.00	1,904,620,935.35
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,000,000.00	11,975,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,628,250,000.00	1,858,701,535.35
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,944,400.00	33,944,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,995,961,200.00	5,226,412,735.35
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,367,711,200.00	3,367,711,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,367,711,200.00	3,367,711,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,628,250,000.00	1,858,701,535.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,628,250,000.00	1,858,701,535.35
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	185	185
620001	Удирдах ажилтан	15	15
620002	Гүйцэтгэх ажилтан	122	122
620003	Үйлчлэх ажилтан	48	43
620004	Гэрээт ажилтан		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	185	185
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	137	137
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	48	48

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/69/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын	Ашигт малтмал, газрын тосны газар			мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Насжилт ихтэй авлага, өглөг үүсгэсэн, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	8,346,380.7	Албан шаардлага	Дарга, ахлах нягтлан бодогч	Х.Хэрлэн, Т.Цэрэндулам
2	Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалсан.	769,548.5	Албан шаардлага		
3	Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд /аккруэль/ давхар бүртгэсэн. Өөрийн орлого буюу Сонгон шалгаруулалтын орлогыг Урьдчилж орлогоор бус байгууллагад төлөх өглөгөөр бүртгэсэн.		Зөвлөмж		
4	Газрын тосны тухай хуулиар зөвшөөрөгдсөн, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгагдсан "Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих орлого"-ыг төсөвт тусгаж батлуулалгүйгээр зарцуулсан байна.	1,311,519.5	Зөвлөмж		
5	Сангийн яамны Төрийн сангийн газарт анхан шатны баримт материалыг хянан хүлээн авч, шилжүүлсэн орлогын буцаалтын ажил гүйлгээг мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	2,368,584.8	Зөвлөмж		
6	Мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын дансыг бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнаагүй.	530,849.7	Зөвлөмж		
7	Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй.	67,850.3	Зөвлөмж		
8	Нормын хувцасыг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	24,250.7	Зөвлөмж		
Дүн		3,418,984.1			